



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/280

Хэрлэн сум

Улсын үзлэг зохион байгуулах  
ажлын хэсэг томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг боловсролын байгууллагын салбарт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам, нийгмийн, хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хүүхэд залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын мэргэжилтэн (улсын байцаагч) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын мэргэжилтэн (улсын байцаагч) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй, байдал хариуцсан мэргэжилтэн Боловсрол, шинжлэх ухааны газрын Боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

2.Боловсролын байгууллагын салбарт хийгдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2023  
231010707